



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ 5 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo>
цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад
танилцуулга, мэдээтэй танилцана уу.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

2025 он | №5

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл: 259.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 2,287.9 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 1,247.0 тэрбум төгрөгөөр бага байна.

Төсвийн орлогын хувьд: 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 10,711.6 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө 1,270.2 тэрбум төгрөг буюу 10.6 хувиар дутуу биелсэн бол өмнөх оны мөн үеэс 1,360.4 тэрбум төгрөг буюу 11.3 хувиар буурсан байна.

- Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 89.4 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөснөөс 1,270.2 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн. Үүнд: Татварын орлого 10.2 хувь буюу 1,143.6 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 15.8 хувь буюу 126.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс тус тус дутуу биелсэн байна.
- Тайлант хугацаанд онцгой албан татвар 2.9 хувиар давж биелсэн бол нийгмийн даатгалын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжийн орлого, орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, тусгай зориулалтын орлого төлөвлөснөөс 2.6-38.1 хувиар төлөвлөснөөс дутуу гүйцэтгэлтэй байна.
- Татварын бус орлогын төлөвлөгөө тайлант хугацааны гүйцэтгэлээр 126.7 тэрбум төгрөг буюу 15.8 хувиар дутуу биелсэн нь түрээсийн орлого, газрын тосны орлого, навигацийн орлого, бусад орлого, тусламжийн орлого, хувьцааны ногдол ашиг 24.9-89.9 хувь дутуу биелснээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 10,971.5 тэрбум төгрөг болж, 2,517.3 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулалттай буюу 81.3 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад 18.7 хувиар дутуу зарцуулагдаж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.2 хувиар буюу 927.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үеэс 7.4 тэрбум төгрөгөөр буурсан бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 43.2 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2025 онд нийт 3,124.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 220.9 тэрбум төгрөгийг зарцуулж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ 5 САРЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн
нийт тэнцэл 259.9 тэрбум
төгрөгийн алдагдалтай гарчээ.

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 10,711.6 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 10,971.5 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 259.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 2,287.9 тэрбум төгрөгөөр өссөн, төлөвлөснөөс 1,247.0 тэрбум төгрөгөөр бага байна.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл
/тэрбум төгрөгөөр/



Өнгөрсөн оны мөн үеэс нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 11.3 хувь буюу 1,360.4 тэрбум төгрөгөөр буурсан бол төсвийн нийт зарлага 9.2 хувь буюу 927.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал 2,287.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тэрбум төгрөгөөр

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	ӨО-ны мөн үед	2025 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь.	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,977.1	-999.6	-173.7	17.4	826.0
Засгийн газрын бонд	603.0	-300.0	-440.0	146.7	-140.0
Засгийн газрын зээл	-552.0	-207.3	353.9	-170.7	561.1
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	0.0	0.0	-	0.0
Өмч хувьчлал	-0.1	0.00	-0.06	-	0.06
НИЙТ ДҮН	-2,028.0	1,506.9	259.9	17.2	-1,247.0

Эх сурвалж: Сангийн яам

2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 230.7 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 584.6 тэрбум төгрөг төлсөн бол 2,031.5 тэрбум төгрөгийн урт хугацаат гадаад бонд шинээр гаргаж, урт хугацаат гадаад бондын үндсэн төлбөрт 1,731.5 тэрбум төгрөг төлсөн байна. Харин 140.0 тэрбум төгрөгийн урт хугацаат дотоод бонд шинээр гаргасан байна.

“
Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 10,711.6 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 11.3 хувь буюу 1,360.4 тэрбум төгрөгөөр, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 10.6 хувь буюу 1,270.2 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.
 ”

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл улсын төсөв 14.5 хувь буюу 1,090.8 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 16.4 хувь буюу 571.0 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 6.9 хувь буюу 72.4 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 0.4 хувь буюу 11.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс тус тус дутуу төвлөрчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 22.8 хувь буюу 181.6 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 13.4 хувь буюу 312.8 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 10.0 хувь буюу 264.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлогын 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Тэрбум төгрөгөөр

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,728.8	6,625.9	3,486.5	2,915.5	2,661.6	2,650.0	1,049.3	976.9
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	198.3	186.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,530.5	6,439.7	3,486.5	2,915.5	2,661.6	2,650.0	1,049.3	976.9
Татварын орлого	6,183.8	5,536.4	2,841.5	2,422.4	2,006.3	1,994.7	1,049.3	976.9
Орлогын албан татвар	1,459.9	1,267.8	2,403.5	2,008.0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	2,006.3	1,994.7	1,049.3	976.9
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	232.9	227.0	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,558.7	2,292.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	464.2	477.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	16.1	10.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	815.0	722.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	869.9	766.5	205.1	187.4	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	1,346.7	903.3	645.0	493.2	655.2	655.2	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	428.1	375.9	233.9	210.2	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	2.9	3.4	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	133.9	87.8	5.8	1.1	655.2	655.2	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	784.7	439.5	402.5	278.5	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 93.7 хувийг татварын орлого, 6.3 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 11.3 хувь буюу 1,282.7 тэрбум төгрөгөөр татварын бус орлого 10.3 хувь буюу 77.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.


“

Татварын орлого 10,035.4 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө 10.2 хувь буюу 1,143.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

”

Татварын орлогын 32.6 хувийг орлогын албан татвар, 20.7 хувийг нийгмийн даатгалын орлого, 2.3 хувийг хөрөнгийн албан татвар, 22.3 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 4.8 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 7.2 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 9.5 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /Тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд татварын орлого төлөвлөснөөс 10.2 хувь буюу 1,143.6 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 10.4 хувиар (266.3 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 2.6 хувиар (5.9 тэрбум төгрөг), орлогын албан татвар 15.2 хувиар (587.6 тэрбум төгрөг) тус тус төлөвлөснөөс дутуу биелсэн нь нөлөөлжээ.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр татварын орлого 11.3 хувь буюу 1,282.7 тэрбум төгрөгөөр буурахад орлогын албан татвар 14.1 хувь (535.7 тэрбум төгрөг)-аар, бусад татвар, төлбөр хураамж 57.6 хувь (1,297.2 тэрбум төгрөг) -аар тус тус буурсан нь нөлөөлжээ.

“
Татварын бус орлого 676.2 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 77.6 тэрбум төгрөгөөр буурсан бол төлөвлөснөөс 126.7 тэрбум төгрөг буюу 15.8 хувиар дутуу төвлөрчээ.
”

Төлөвлөгөөтэй харьцуулахад торгуулийн орлого 8.2 тэрбум төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 68.1 тэрбум төгрөгөөр, хүүгийн орлого 8.9 тэрбум төгрөгөөр төгрөгөөр тус тус давж биелжээ.

Харин навигацийн орлого 8.3 тэрбум төгрөг, газрын тосны орлого 70.4 тэрбум төгрөг, бусад орлого 80.9 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

График 4. Татварын бус орлогын бүтэц /Хувиар/



Татварын бус орлогын 86.7 хувийг нийтлэг татварын бус орлого, 12.8 хувийг тусламжийн орлого, 0.5 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна.

Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 10.8 хувийг хүүгийн орлого, 15.7 хувийг торгуулийн орлого, 12.7 хувийг газрын тосны орлого, 41.8 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.2 хувийг түрээсийн орлого, 4.3 хувийг навигацийн орлого эзэлсэн бол 14.4 хувийг бусад орлого бүрдүүлж байна.

“

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 927.5 тэрбум төгрөг буюу 9.2 хувиар өссөн байна.

”

3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 13,488.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 81.3 хувь буюу 2,517.3 тэрбум төгрөгийг дутуу зарцуулж, 10,971.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлагын 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэл /төсвийн шатлалаар/

Тэрбум төгрөгөөр

Зардлын зүйл	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,081.8	7,362.6	4,597.3	2,381.7	2,470.6	2,415.9	1,085.1	1,081.9
НИЙТ ЗАРЛАГА	8,020.1	7,410.2	4,500.2	2,321.2	2,470.6	2,416.2	1,085.1	1,083.0
УРСГАЛ ЗАРДАЛ	7,330.6	7,011.8	2,504.2	1,637.3	2,470.6	2,416.2	1,085.1	1,083.0
Бараа, ажил, үйлчилгээний зардал	3,485.2	3,341.9	1,348.5	951.4	0.7	0.4	4.8	4.4
Зээлийн үйлчилгээний төлбөр	535.4	493.9	25.2	23.5	0.0	0.0	0.0	0.0
Татаас	848.0	847.9	184.4	178.9	0.0	0.0	0.0	0.0
Урсгал шилжүүлэг	2,462.0	2,327.9	946.0	483.5	2,469.8	2,415.8	1,080.3	1,078.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	689.5	398.4	1,996.0	683.9	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	61.7	-47.6	97.1	60.4	0.0	-0.3	0.0	-1.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-551.3	-922.8	-1,110.8	533.8	191.0	234.1	-35.8	-105.0

Эх сурвалж: Сангийн яам

Улсын төсвийн зарлага тайлант хугацаанд төлөвлөснөөс 719.2 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 2,215.7 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 54.7 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 3.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 9.2 хувь буюу 927.5 тэрбум төгрөгөөр өсөхөд урсгал зардал 1,509.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

“

Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.4 тэрбум төгрөгөөр буурсан бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 7.7 хувь буюу 43.2 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулалттай гарсан байна.

”

Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл /зардлын эдийн засгийн ангиллаар/

Тэрбум төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	ӨО-ны мөн үе	2025 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,043.9	13,488.7	10,971.5	-18.7	-2,517.3
НИЙТ ЗАРЛАГА	9,824.1	13,329.9	10,960.1	-17.8	-2,369.8
УРСГАЛ ЗАРДАЛ	8,368.1	10,644.4	9,877.7	-7.2	-766.7
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,354.1	4,568.5	4,034.3	-11.7	-534.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,023.9	2,698.5	2,631.1	-2.5	-67.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235.3	342.4	280.7	-18.0	-61.7
Хангамж, бараа материалын зардал	101.4	116.1	100.1	-13.8	-16.0
Нормативт зардал	116.9	130.2	127.0	-2.5	-3.2
Эд хогшил, урсгал засварын зардал	57.7	96.5	55.7	-42.3	-40.9
Томилолт, зочны зардал	21.5	40.3	32.0	-20.6	-8.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400.7	606.0	389.9	-35.7	-216.1
Бараа үйлчилгээний бусад зардал	396.6	538.5	417.8	-22.4	-120.6
ХҮҮ	524.9	560.6	517.5	-7.7	-43.2
ТАТААС	261.8	377.2	371.6	-1.5	-5.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,227.3	5,138.1	4,954.4	-3.6	-183.7
Засгийн газрын урсгал шилжүүлэг	994.8	1,338.5	1,236.7	-7.6	-101.8
Бусад урсгал шилжүүлэг	3,232.5	3,799.6	3,717.7	-2.2	-81.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,456.0	2,685.5	1,082.3	-59.7	-1,603.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	219.8	158.8	11.4	-92.8	-147.4


Эх сурвалж: Сангийн яам

“
Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд урсгал зардлын эзлэх хувийн жин 90.0 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 6.7 пунктээр өссөн байна.
”

График 5. Урсгал зардлын бүтэц /Хувиар/

“
Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар 39 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд эхний 05 сарын гүйцэтгэлээр нийт зарлага 719.2 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж 91.1 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
”

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 90.1 хувь буюу 9,877.7 тэрбум төгрөг нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 50.2 хувийг урсгал шилжүүлэг, 40.8 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 26.6 хувийг цалин хөлсний зардал, 5.2 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.9 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 3.8 хувийг татаас, 9.9 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 1,509.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: бараа, ажил үйлчилгээний зардал 680.3 тэрбум төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшил 607.2 тэрбум төгрөгөөр, урсгал шилжүүлэг 727.1 тэрбум төгрөгөөр, татаас 109.8 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.



” Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлагын 33.1 хувийг Сангийн сайдын багц, 56.8 хувийг Боловсролын сайдын багц, 59.1 хувийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 23.4 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 17.5 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, үлдэх 10.0 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын зардал эзэлж байна.

Хүснэгт 6. Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Сая төгрөгөөр

Төсвийн ерөнхийлөн захирагч	2025 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	9,024.0	9,022.9	-1.1	100.0
Монгол Улсын Их Хурлын дарга	46,861.7	46,853.8	-7.9	100.0
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	2,084.4	2,084.4	0.0	100.0
Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	7,427.0	7,425.4	-1.5	100.0
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	68,893.3	68,708.1	-185.2	99.7
Улсын ерөнхий прокурор	54,419.8	54,214.4	-205.4	99.6
Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	11,017.4	11,017.4	0.0	100.0
Монгол Улсын Ерөнхий сайд	151,166.1	136,418.6	-14,747.5	90.2
Монгол Улсын Шадар сайд /онцгой байдлын асуудал эрхэлсэн/	100,797.4	100,495.5	-302.0	99.7
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	28,656.4	28,641.2	-15.2	99.9
Сангийн сайд	1,625,509.5	1,012,970.2	-612,539.3	62.3
Хууль зүй, дотоод хэргийн сайд	540,154.3	533,478.6	-6,675.7	98.8
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	58,463.1	58,304.7	-158.4	99.7
Батлан хамгаалахын сайд	288,460.0	269,678.1	-18,781.9	93.5
Боловсролын сайд	1,756,841.2	1,737,294.6	-19,546.5	98.9
Гадаад харилцааны сайд	87,042.0	72,045.6	-14,996.4	82.8
Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	9,567.3	7,710.6	-1,856.7	80.6
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	274,439.3	254,394.4	-20,044.9	92.7
Эрүүл мэндийн сайд	716,699.8	716,637.0	-62.8	100.0
Төрийн албаны зөвлөлийн дарга	2,821.2	2,731.2	-90.0	96.8
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	8,731.2	8,731.2	0.0	100.0
Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга	3,679.9	3,679.9	0.0	100.0
Монгол Улсын Ерөнхий аудитор	19,024.4	19,023.5	-0.8	100.0
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	6,824.5	6,824.5	0.0	100.0
Үндэсний статистикийн хорооны дарга	9,301.6	9,301.6	0.0	100.0
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга	613.5	613.5	0.0	100.0
Зам, тээврийн сайд	64,127.0	62,963.5	-1,163.4	98.2
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	34,101.1	32,401.5	-1,699.6	95.0
Эрчим хүчний сайд	46,489.3	46,374.5	-114.8	99.8
Авлигатай тэмцэх газрын дарга	21,731.2	20,918.6	-812.6	96.3
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	142,970.6	139,561.3	-3,409.3	97.6
Монгол Улсын Шадар сайд /өрсөлдөөний асуудал эрхэлсэн/	2,223.5	2,184.8	-38.7	98.3
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1,807,968.5	1,806,535.1	-1,433.4	99.9
Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга	4,644.0	4,643.4	-0.6	100.0
Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга	924.8	924.8	0.0	100.0
Шүүхийн сахилгын хорооны дарга	2,152.7	1,932.7	-220.0	89.8
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд, Эдийн засаг, хөгжлийн сайд	49,637.4	49,508.2	-129.1	99.7
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	14,529.9	14,537.3	7.4	100.1
Монгол Улсын сайд, боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга	1,777.7	1,777.7	0.0	100.0
НИЙТ ЗАРДАЛ	8,081,798.0	7,362,564.4	-719,233.5	91.1

Эх сурвалж: Сангийн яам

2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 220.9 тэрбум төгрөгийг зарцуулж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2025 онд нийт 3,124.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 220.9 тэрбум төгрөгийг зарцуулж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл Сая төгрөгөөр

Хуулийн дугаар	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	2025 оны төсөв	2025 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
			Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
I	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ	1,000.0	-	-	0.0	-
II	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	8,560.0	0.0	0.0	0.0	-
III	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	1,545.5	359.8	359.8	0.0	100.0
IV	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	51,444.9	5,728.9	5,728.9	0.0	100.0
V	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	42,477.6	359.8	359.8	0.0	100.0
VI	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	24,230.6	1,818.9	1,818.9	0.0	100.0
VII	МОНГОЛ УЛСЫН САЙД, 20 МИНУТЫН ХОТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	15,671.5	0.0	0.0	0.0	-
VIII	МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	8,098.5	0.0	0.0	0.0	-
IX	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	11,250.4	5,772.4	5,772.4	0.0	100.0
X	САНГИЙН САЙД	126,249.3	3,716.9	3,714.7	2.2	99.9
XI	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	108,551.9	3,148.4	3,148.4	0.0	100.0
XII	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	75,403.9	14,687.0	14,687.0	0.0	100.0
XIII	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	80,829.8	904.2	904.2	0.0	100.0
XIV	БОЛОВСРОЛЫН САЙД	472,677.8	48,765.9	48,765.9	0.0	100.0
XV	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	52,242.3	8,040.7	8,040.7	0.0	100.0
XVI	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	951,219.0	44,472.4	44,472.4	0.0	100.0
XVII	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	145,245.7	20,755.7	20,755.7	0.0	100.0
XVIII	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	354,097.3	27,351.5	27,351.5	0.0	100.0
XIX	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	58,580.5	4,946.7	4,946.7	0.0	100.0
XX	ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	35,745.1	0.0	0.0	0.0	-
XXI	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	196,193.2	8,471.0	8,471.0	0.0	100.0
XXII	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	193,095.6	10,380.1	10,380.1	0.0	100.0
XXIII	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	2,360.9	0.0	0.0	0.0	-
XXIV	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	4,628.2	0.0	0.0	0.0	-
XXV	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	62,984.5	0.0	0.0	0.0	-
XXVI	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	29,849.1	10,979.4	10,979.4	0.0	100.0
XXVII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1,178.8	0.0	0.0	0.0	-
XXVIII	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	250.0	0.0	0.0	0.0	-
XXIX	ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА	300.0	220.0	220.0	0.0	100.0
XXX	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	2,712.0	0.0	0.0	0.0	-
XXXI	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	2,000.0	0.0	0.0	0.0	-
XXXII	МОНГОЛ УЛСЫН САЙД, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	2,408.1	0.0	0.0	0.0	-
XXXIII	АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД	984.0	0.0	0.0	0.0	-
НИЙТ		3,124,066.0	220,879.7	220,877.5	2.2	100.0

Эх сурвалж: Сангийн яам


Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд “Барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлэхээр 107.1 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг Монгол Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төсөвлөснөөс 2025 оны эхний 5 сарын байдлаар 10.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгаж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 8. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барих-шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэл Сая төгрөгөөр



ҮЗҮҮЛЭЛТ	2025 оны төсөв	2025 оны эхний 5 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	107,132.1	10,983.4	10,983.4		100.0
Эдийн засаг, хөгжлийн яам	107,132.1	10,983.4	10,983.4		100.0
Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 120.85 км /Дархан, Сэлэнгэ, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Зэлтэр сум/	96,148.6				-
Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төслийн шүүхийн шийдвэрийн дагуу хийгдэх эргэн төлөлт /Баянхонгор/	10,983.5	10,983.4	10,983.4		100.0

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

/Тэрбум төгрөгөөр/



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН



↑ -Өөрчлөлт (Өнгөрсөн оны мөн үеэс)


Монгол Улсын 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэл

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс

Нийгмийн даатгалын сангийн зарлагад 2,415.9 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 418.2 тэрбум төгрөг буюу 20.9 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэврийн даатгалын сангийн зарлага 352.6 тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 24.8 тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ий даатгалын сангийн зарлага 1.9 тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 24.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын санд нийт 2,650.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 0.4 хувь буюу 11.6 тэрбум төгрөгөөр дутуу биелэн орлогын гүйцэтгэл 38.3 хувьтай гарсан байна.


График 6. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын бүтэц /Хувиар/



6. Эрүүл мэндийн даатгалын сан

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 6.9 хувиар дутуу биелжээ.


График 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /Тэрбум төгрөгөөр/



Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 976.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 6.9 хувь буюу 72.4 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,081.9 тэрбум төгрөгийн зарлага хийгдэж өнгөрсөн оны мөн үеэс 202.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

График 8. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Тэрбум төгрөгөөр/



2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 1,085.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, 1,081.9 тэрбум төгрөгийг зарцуулж, 99.7 хувийн гүйцэтгэлтэй гарчээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тус сангийн нийт зарлага 202.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 2,215.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

7. Орон нутгийн төсөв

2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 2,915.5 тэрбум төгрөг болж төлөвлөсөн дүнгээс 16.4 хувь буюу 571.0 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн бол орон нутгийн төсвийн нийт зарлага 2,381.7 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 48.2 хувь буюу 2,215.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж, орон нутгийн төсвийн тэнцэл 17.9 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 10.0 хувиар буюу 264.0 тэрбум төгрөгөөр, нийт зарлага 44.8 хувь буюу 736.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 90.4 хувийг орон нутгийн төсвийн орлого, 6.4 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 3.2 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг тус тус эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 186.5 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөгдөж 100 хувийн гүйцэтгэлтэй, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэгт 215.9 тэрбум төгрөг шилжүүлэхээр төлөвлөгдөж, 91.9 тэрбум төгрөг буюу 42.6 хувийн гүйцэтгэлтэй тус тус гарсан байна.

Орон нутгийн нийт орлого төлөвлөснөөс 571.0 тэрбум төгрөг буюу 16.4 хувиар дутуу төвлөрсөн нь орон нутгийн татварын орлого 14.7 хувь буюу 419.1 тэрбум, татварын бус орлого 23.5 хувь буюу 151.9 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

График 9. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



Хүснэгт 8. Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Сая төгрөгөөр

АЙМАГ	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	19,359.3	19,359.3	100.0	5,260.1	2,116.7	40.2
Баян-Өлгий	12,358.2	12,358.2	100.0	5,065.4	2,060.9	40.7
Баянхонгор	16,735.5	16,735.5	100.0	8,353.6	3,763.4	45.1
Булган	7,456.4	7,456.4	100.0	5,492.8	2,508.2	45.7
Говь-Алтай	12,368.8	12,368.8	100.0	8,964.6	3,870.8	43.2
Дорноговь	0.0	0.0	0.0	19,938.3	8,757.5	43.9
Дорнод	0.0	0.0	0.0	10,970.1	5,147.2	46.9
Дундговь	8,045.3	8,045.3	100.0	6,469.9	3,051.3	47.2
Завхан	19,868.5	19,868.5	100.0	6,253.0	2,600.9	41.6
Өвөрхангай	15,150.8	15,150.8	100.0	6,254.9	2,791.6	44.6
Өмнөговь	-	-	0.0	21,742.1	9,632.3	44.3
Сүхбаатар	9,340.5	9,340.5	100.0	9,593.9	4,245.0	44.2
Сэлэнгэ	-	-	0.0	11,321.1	4,713.9	41.6
Төв	897.5	897.5	100.0	10,370.5	4,415.1	42.6
Увс	16,488.8	16,488.8	100.0	5,936.6	2,394.9	40.3
Ховд	5,850.7	5,850.7	100.0	11,037.0	4,852.0	44.0
Хөвсгөл	21,738.9	21,738.9	100.0	7,574.2	3,423.8	45.2
Хэнтий	17,020.6	17,020.6	100.0	8,566.4	3,664.7	42.8
Дархан-Уул	-	-	0.0	7,733.2	2,973.9	38.5
Улаанбаатар	-	-	0.0	21,935.0	8,372.9	38.2
Орхон	-	-	0.0	14,070.3	5,283.7	37.6
Говьсүмбэр	3,867.5	3,867.5	100.0	3,029.1	1,330.5	43.9
ДҮН	186,547.3	186,547.3	100.0	215,931.9	91,971.1	42.6

Эх сурвалж: Сангийн яам

Орон нутгийн орлогыг аймгуудаар харуулбал: Дундговь аймаг 4.9 сая, Сэлэнгэ аймаг 405.1 сая, Хэнтий аймаг 814.6 сая төгрөгөөр төлөвлөгөөг давуулан биелүүлсэн бол Архангай аймаг 2,426.7 сая, Баян-Өлгий аймаг 7,741.8 сая, Баянхонгор аймаг 4,640.4 сая, Булган аймаг 4,886.9 сая, Говь-Алтай аймаг 2,508.9 сая, Дорноговь аймаг 37,604.6 сая, Дорнод аймаг 9,930.9 сая, Завхан аймаг 2,738.4 сая, Өвөрхангай аймаг 3,866.0 сая, Өмнөговь аймаг 328,762.4 сая, Сүхбаатар аймаг 5,798.7 сая, Төв аймаг 2,268.1 сая, Увс аймаг 6,477.7 сая, Ховд аймаг 9,363.9 сая, Хөвсгөл аймаг 977.7 сая, Дархан-Уул аймаг 906.2 сая, Орхон аймаг 16,298.8 сая, Говьсүмбэр 2,050.5 сая төгрөгөөр Улаанбаатар хот 123,562.3 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрүүлсэн байна.